

АРДЫН ХУВЬСГАЛЫН 60 ЖИЛИЙН ОЙД

СЭТГҮҮЛИЙН «ДУГУЙ ШИРЭЭ»

Ардын хувьсгалын 60 жилийн ойд зориулсан «Монгол Ардын Хувьсгалын 60 жил» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон ах дүү социалист орны төлөөлөгчдийг урьж, зохион байгуулсан тус сэтгүүлийн «дугуй ширээ»-ний ярианд оролцогчид хувьсгалын жилд манай орны олсон ололт амжилт, хөгжлийн түүхэн туршлага, гадаад дотоод бодлогын олон улсын ач холбогдлыг өндөр үнэлэхийн зэрэгцээгээр БНМАУ ба ах дүү социалист орны олон талт хамтын ажиллагаа, тэдгээр орны хөгжлийн нийтлэг ба онцлог, ялангуяа улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхтэй холбогдсон цаг үеийн чухал сэдвийг хөндөн ярилцлаа. «Дугуй ширээ»-ний ярианд ах дүү орны нэрт эрдэмтэд, тухайлбал академич Минц (ЗСБНХУ), профессор Милан Матоуш (БНСЧСУ) профессор Вела Веси (БНУАУ), доцент Н. И. Киров (БНБАУ), Во Куанг Чин (БНСВУ). Дж. Каргар, (БНААФУ), Феликс Алварес (БНСКУ) нарын зэрэг нөхдөөс гадна манай улсын академич, нэрт эрдэмтэд оролцлоо. «Дугуй ширээний» ярианаас дор сийрүүлэв.

И. И. МИНЦ (ЗХУ-ын хөдөлмөрийн баатар, академич)

—60 жилийн турш Монгол орны туулж өнгөрүүлсэн замын агуулга, мөн чанарыг товчоор нийтэд илэрхий хэлбэрээр тодорхойлох хэрэгтэй гэвэл цагаан толгойн үсгээс сансар хүртэлх замыг туулсан юм гэж би хэлмээр байна. Хөгжингүй соёл иргэншлийн төв замаас империализмаар таслагдаж хоцрогдсон орон хувьсгалын дараа бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах анхны алхмаа цагаан толгойн үсгийг танихаас эхэлж байсан бол одоо сансар огторгуйг танин мэдэх хүртлээ өсч хөгжсөн орон болоод байна. Энэ бүхнийг зөвхөн нэгэн үеийнхний амьдрах хугацаанд хийж амжжээ.

Энэ гайхамшигт амжилтыг тодорхойлогч ямар нөхцөл байв гэвэл Нэн түрүүнд Аугаа их Октябрийн социалист хувьсгалын үүрэг, ач холбогдлыг хэлэх хэрэгтэй. Энэ хувьсгал дэлхий ертөнцийг ороож хүлсэн империализмын гав гинжийг тас татаж, хөдөлмөрчин олон түмнийг нухчин дарж байсан хүнд дарамтыг авч хаяснаар ард түмний тал бүрийн бүтээлч хүч цэцэглэн мандах боломжийг нээлээ. Аугаа их Октябрийн хувьсгал нь эрх чөлөө тусгаар тогтнолд хүрэх болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс чөлөөлөх цорын ганц зөв замыг зааж өгсөн юм.

Монгол орон бол нэн чухал энэхүү замыг сонгон авсан анхны орон бөгөөд Октябрийн аугаа их үзэл санааг шинэ нийгэм байгуулахад анх удаа удирдах зарчмаа болгосон юм. Империализм феодализмын эсрэг хувьсгал эхэлж байсан үе болох 1921 онд домогт баатар Д. Сүхбаатараар удирдуулсан монголын хувьсгалчид монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг Зөвлөлт орны пролетари нартай холбон хувьсгалын ялалтыг хангасан юм. Гурван жилийн дараа 1924 онд хуралдсан МАХН-ын III их хурал нь тус оронд социализм байгуулах ганц зөв зам бол капиталист биш хөгжлийн зам гэдгийг тодорхой заасан юм.

МАХН-аар удирдуулсан монголын ард түмний баатарлаг тэмцлийн 60 жилийн түүх бол зөв замыг сонгон авсны гэрч юм. Хичнээн ауга

их ач холбогдолтой байсан ч Октябрийн хувьсгалын дан ганц нөлөө ялалтыг тодорхойлж чадахгүй юм. Үүсэн бий болсон шалтгааныг ашиглаж хөгжлийн явцыг ашигтай зүг рүү чадмаг чиглүүлж өгөх нийгмийн тийм хүч нь МАХН болсон билээ. МАХН-ын гарамгай гавъяа бол: хоцрогдсон ба колонийн орнуудын капиталист биш хөгжлийн онол, практикийг боловсруулсан явдал юм.

ДЖЕЛАНИ КАРГАР (Афганистаны Ардын Ардчилсан Намын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институтын орлогч захирал)

Афганы Дөрөвдүгээр сарын хувьсгал бол үндэсний ардчилсан хувьсгал юм. Энэ хувьсгал нийгмийн ардчилсан зорилтуудыг шийдвэрлэж байна. Ардчилсан Афганистан улсын 1981 оны үндсэн зарчимуудад тодорхойлсноор манай хувьсгалын гол ололт бол хот хөдөөгийн хөдөлмөрчин олон түмний гарт шилжсэн шинэ хэлбэрийн засаг төрийг байгуулсан явдал юм. Дөрөвдүгээр сарын хувьсгал үндсэн хоёр үе шатанд хуваагддаг. Нэгдүгээр шатны эхэн үед Ардчилсан Афганистан улс байгуулагдаж, Ардчилсан Афганистан улсын засгийн газар, хувьсгалт ээвлэл бүрэлдэн тогтсон юм.

Амин, түүний хөнөөлт дээрэмчдийг зайлуулснаар хувьсгалын шинэ үе шат эхэлсэн болно.

АААН, БНААфГУ-ын засгийн газар хувьсгалын шинэ үе шатанд империализм, феодализмын эсрэг эх оронч нэгдмэл фронт байгуулах үйл хэрэгт ихээхэн амжилт оллоо.

—Монгол дахь Ардын хувьсгал бол Монголын түүхэнд эргэлтийн үе болсон билээ. Ардын хувьсгал монгол орныг хоцрогдсон нүүдлийн мал аж ахуйн орноос орчин үеийн эдийн засгийн олон салбар, өндөр соёлтой хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болгон хувиргасан явдал урьд хоцрогдмол байсан орон капиталист биш хөгжлийн замаар феодализмаас социализмд шилжиж болох тухай Лениний сургаал ялан мандаж байгааг яруу тодоор гэрчлэн харуулж байна.

Өнөөдөр Монголын үйлдвэр 1924 онд нэг жилийн турш гаргаж байсан бүтээгдэхүүнийг 13 минутад гаргаж байна. Энэ бол үнэхээр гайхалтай том амжилт юм. Бид «Монгол Ардын Хувьсгалын 60 жил» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр БНМАУ-ын эдийн засаг, соёлын хөгжилтийн талаар ихээхэн зүйлийг сонсож ах дүү орнууд, ялангуяа ЗХУ-ын интернационалч тусламжийн үр дүнд хувьсгал ялснаас хойших 60 жилд бий болсон нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтийг нүдээрээ үзлээ.

ИВАН КИРОВ (БНБАУ-ын Нийгмийн ухааны Академийн марксизм-ленинизмийн институтын олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний тэнхмийн орлогч эрхлэгч, Доцент)

—БНМАУ-ын туршлага бол ялсан пролетарийн тусламжтай хөгжлийн капиталист шатыг алгасч социализмд хүрч болох тухай марксист ленинист сургаал зөв болохын яруу тод баталгаа юм. Энэ нь нэг талаас олонхи орны хувьд хөгжлийн замаа зөв сонгох асуудал бол хоцрогдлоос гарах ганц зам, нөгөө талаас эдгээр орнуудад социалист систем ихээхэн тусламж үзүүлэх чадвартай болсон өнөө үед бүр чухал болж байна. «Гурав дахь ертөнцийн» олон орон юуны өмнө Африкийн орнууд хөгжлийн капиталист биш зам, социалист чиг баримжааг сонгон авч байна. Хувьсгалын капиталист биш хөгжлийн шатан дахь МАХН-ын роль бол социалист чиг баримжааг сонгон авч байгаа залуу орны хувьд бүр ч сургамжтай юм. Энэ нь орон бүрийн хувьсгал өөрийн өвөрмөц онцлогийг харгалзахын зэрэгцээгээр хувьсгалын ерөнхий үндсэн зүй тогтлыг хадгалсан байх ёстой гэсэн үг юм.

МАХН-ын гадаад улс төрийн бодлого, МАХН-ын XVIII их хурлын энх тайванч санаачилга нь эрин үеийн чухал асуудлуудад танай нам үр

бүтээлтэй бодит байдлаар хандаж буйг баталж байна. Эдгээр санал нь шинжлэх ухааны үндэстэй гүн гүнзгий бодож боловсруулсан санал бөгөөд ЗХУКН-ын XXVI их хурлаас болон социалист нөхөрлөлийн орнуудын ах дүү бусад намуудын их хурлуудаас боловсруулсан бодлогод МАХН хэрхэн хандаж буйн тусгал болж байгаа юм.

ВО КУАНГ ЧИН (Вьетнамын Коммунист Намын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуулийн орлогч захирал)

«Монгол Ардын Хувьсгалын 60 жил» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал сайхан үр дүнтэй боллоо. Хоцрогдсон хөдөө аж ахуйн орон, капиталист хөгжлийн шатыг алгасан социализмд шилжин орж болох тухай их Лениний сургаалийг хүн төрөлхтний түүхэнд анх удаа бүтээлчээр хэрэгжүүлсэн явдал монголын ард түмний гайхамшигт ялалт» юм гэж марксизм-ленинизмын онолын үүднээс бүх эрдэмтэд үнэлэн дүгнэлээ. Эдүгээ Монгол орон эрх чөлөө, тусгаар тогтнолоо найдвартай хамгаалах, хоцрогдол, өлсгөлөн гуйланчлалыг устгах, колони байсан болон, дорой буурай хөгжилтэй орны ард түмэнд социализмы төлөө тэмцэхэд нь шинжлэх ухааны зоригжуулагч хүч нь болж байна.

Социалист Вьетнам Улс, БНМАУ хоёр бол түүхэн урт удаан хугацааны харилцаатай, ЗХУ болон социалист системийн аугаа их гэр бүлд багтдаг Ази тивийн ах дүү орнууд бөгөөд Октябрийн хувьсгалын гэрэлт замаар олон улсын харгис хүч, империализмын эсрэг, социализм, ардчилал, үндэсний тусгаар тогтнол, энх тайвны төлөө тэмцэлд хамт замнаж байна. «Вьетнамаас савраа тат» гэсэн монголын ард түмний шийдвэртэй үг, Вьетнамд туслах фондод зориулсан коммунист субботник, вьетнамын ард түмэн, коммунистуудын сэтгэл зүрхэнд мөнхөд үлдэж социализмыг тууштай хатуу баримтлах, Зүүн Өмнөд Азид социализмыг манлайлах үүргээ биелүүлэхэд зоригжуулагч их хүчийг бидэнд өгч байна.

Империализм олон улсын харгис хүчний хорлон сүйтгэгч, шунахай явууллагын эсрэг Вьетнам, Монголын эв санааны дайчин нэгдэл, бүх талын хамтын ажиллагаа хэлхээ холбоог цаашид улам гүнзгийрүүлж, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэх явдал бол Вьетнам, Монголын ард түмний хувьд хойшлуулшгүй амин чухал зорилго байх ёстой. В. И. Ленин «өөрийгөө хамгаалж чаддагтаа л ямарч хувьсгалын үнэ цэнэ орших ёстой» гэж сургасан билээ.

ФЕЛИКС АЛВАРЕС (Кубын Коммунист Намын Дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч)

—Монгол Ардын Хувьсгал нь хүн төрөлхтний түүхэнд томоохон чухал үйл явдал болж орсон билээ.

Танай хувьсгал суут Лениний удирдсан Октябрийн их хувьсгалын шууд тусгал үргэлжлэл нь мөн бөгөөд хоцрогдсон оронд социалист хувьсгал ялж болох тухай их Лениний онолын дүгнэлтийг амьдрал практик дээр яруу тод нотолж, өнөөгийн шинэ тулгар улс орнуудын хөгжил дэвшлийн хамгийн зөв зам бол социалист чиг баримжаа гэдгийг батлан өгч байна.

—Манай хувьсгал ялснаас хойш 22 жил боллоо. Энэ хувьсгал өөрийн хамгийн хүчирхэг дайсан хойд америкийн империализмаас 90-хэн бээрийн зайтай орших нутагт ялсан билээ. Нэгдэн нягтарсан социалист орнууд, юуны урьд Зөвлөлүүдийн аугаа их орны дайчин эв санааны нэгдэлд зоригжсон тийм ард түмний эрс шийдмэг тэмцэл ямар үр дүн, ач холбогдолтой байдгийг манай хувьсгал нотоллоо.

Куба оронд ялан мандсан энэ хувьсгал Латин Америкийн улс түмний тэмцлийн түүхэнд цоо шинэ үе шатыг нээсэн билээ.

Хувьсгал хийж ялалт байгуулсны дараа хойд Америкийн империализм манай хувьсгалын үйл явцыг таслан саатуулах, улмаар хөнөөн устгахыг хичээхдээ манай эх орны эсрэг бүх фронтоор дайсагнасан явуул-

лага үйлдэж эхэлсэн юм. Гэвч Плайя Хироноор 1961 онд цөмрөн дайрсан дайралтыг бид 72-хон цагийн дотор таслан зогсоож, бут ниргэсэн нь цэргийн талаар Латин Америкт империализмын хүлээсэн анхны ялагдал байлаа гэж болно.

1962 онд АНУ-ын үүсгэсэн хямрал нь хувьсгалыг өөрөө хийж, өөрөө хамгаалж байгаа, түүний үйл хэрэгт үнэнч ЗХУ болон ах дүү социалист орнууд, дэвшилт бүх улс түмний эв санааны дайчин нэгдэл, бүх талын дэмжлэгт түшиглэсэн тийм ард түмнийг аливаа зэвсгийн хүчээр, ямарваа шахалт хавчилтаар айлган сүрдүүлж, мохоон буулгаж авч болдоггүй юм байна гэсэн нэгэн үнэн, хатуу сургамжийг империалистуудад өгсөн юм. Чухамдаа 1962 оны энэ хямралаас эхлэн Америкийн империализм зөвхөн Латин Америкийн Кубад төдийгүй, улмаар Азийн Вьетнам болон өөр бусад улс орон, бүс нутагт дараа дараагаар ялагдал сүйрэл хүлээх болсон билээ.

Сүүлийн жилүүдийн үйл явдлаас харахад империализм Латин Америкт өөрийн дур зориг ноёрхлоо тийм ч хялбархан тогтоон барьж тулган хүлээлгэж чадахгүй болжээ. Үүний тодорхой жишээ бол Никарагуа, Гренадын эх орончдын ялалт, Сальвадор, Гватемалын ард түмний амь эрссэн тэмцэл юм.

Латин Америкт олон нийтийн тэмцэл хөдөлгөөн урьд өмнө байгаагүй их хэмжээтэй өрнөх боллоо. Тэр нь улам бүр олон улс орон, нийгмийн янз бүрийн давхрагыг өргөн хамрах болж зорилго чиглэлийнхээ хувьд нийгмийн өөрчлөл байгуулалтын утга агуулгатай болсоор байна. Энэ бүхнээс үзэхэд Латин Америк өнөөдөр үйл явдал өрнөсөн, хувьсгалт тэмцлийн нь хэтийн төлөв дүр зураг тодхон харагдсан тив болжээ гэж хэлж болох байна. Энэ талаар манай намын II их хурлын тайлан илтгэлд яруу сайхан дүгнэн тэмдэглэсэн билээ.

ВЕЛА ВЕСИ (Унгарын Ажилчны Социалист Намын Төв Хорооны дэргэдэх намын дээд сургуулийн орлогч захирал, профессор)

МАХН-ын аугаа их гавьяа бол Лениний сургаалыг улс орны тодорхой онцлог нөхцөлд тохируулан хэрэглэж чадсанд оршино. Капиталист биш хөгжлийн явц дахь зорилтуудыг шийдвэрлэхдээ ЗХУ-ын Дундад Азийн Бүгд Найрамдах Улсуудын үнэт туршлагыг хэрэглэж чадсан нь МАХН-ын улс төрийн бодлого бүрэлдэн төлөвшихөд ихээхэн боломж олгосон юм. Нийгэм эдийн засгийн хувьд туйлын хоцрогдмол байсан нөхцөлд завсрын үе шатыг зайлшгүй дамжих, тодорхой үе шатыг цаг хугацааны хувьд товчлох явдал капиталист биш хөгжлийн онцлог шинжүүдийн нэг байсан юм. Гэвч зарим үе шат нь тодорхой түүхэн нөхцөлөөс шалтгаалж харьцангуй удаан хугацаагаар үргэлжлэх ба тийм нөхцөлд хувьсгалт процессыг удирдаж буй намаас ангийн дайсантай тэмцэх тэмцэлдээ эрс шийдвэртэй, ард олон, түүний холбоотнуудтай харьцахдаа уян хатан, тэвчээртэй байхыг шаарддаг юм. Ах дүү монголын нам өөрийн нийгэм улс төрийн практик ажиллагаандаа эдгээр шинж чанарыг тусган харуулсан юм. Монголын ард түмэнд феодализмыг даван туулахад бараг 20 жил хэрэгтэй байсан билээ. Дараа нь 1959 оны сүүлчээр ардын хувийн аж ахуйтныг өөрчлөн зохион байгуулснаар социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсан юм. Өнгөрсөн нийгмээс хүлээн авсан ангийн бүтцийг өөрчлөхөд мөн л уян хатан тэвчээртэй буурь суурьтай хандахыг шаардаж байв. Үүнээс үзэхэд монголын хувьсгал нь удаан хугацааны хөгжлийн явц байх ёстой боловч Монгол оронд нүүдлийн феодализмаас социализмд хүрэх үйл явц ахар богино хугацаанд хэрэгжсэн билээ.

Социалист чиг баримжаа гарч буй өнөө үед монголын хувьсгалын нийтлэг түүхэн туршлага онцгой ач холбогдолтой. Колони болон хагас колони байгаад тусгаар тогтнолоо олж авсан орнуудад зөвхөн социалист

чиг баримжаагаар хөгжих явдал л үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалан бэхжүүлэх цорын ганц баталгаа бөгөөд харин социализмын интернационалч тусламж бол хөгжлийн энэхүү замын юугаар ч сольшгүй гадаад нөхцөл болно.

МАХН-ын гадаад улс төрийн бодлого бол интернационалч бөгөөд ихээхэн уламжлалтай юм. МАХН, социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай товолж тохирсон үндсэн дээр энх тайвнаар зэрэгцэн орших зарчим, пролетарийн интернационализмын зарчмыг гуйвалтгүй баримталж олон улсын ашиг сонирхолд нийцсэн бодлого явуулж байна. Чухам ийм учраас Ази дахь энх тайван, тогтвортой байдлын талаар танай намын дэвшүүлсэн санал энхийг эрхэмлэгч дэлхийн бүх хүчийг дэмжлэгийг зүй ёсоор хүлээж байна.

Ш. БИРА (БНМАУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич)

—Аугаа их Октябрийн социалист их хувьсгалын хувьсгалжуулагч нөлөөгөөр монгол оронд мандсан ардын хувьсгал феодалын нийгмийн соёлын хоцрогдлыг жинхэнэ хувьсгалт ардчилсан соёлоор халах их боломжийг нээж өгсөн билээ. БНМАУ хүн төрөлхтний түүхэнд анх удаа их Лениний сургаалыг үндэс болгон феодализмаас хөгжлийн капиталист замыг алгасч социализмд шилжсэн орны хувьд түүхэнд анх удаа феодализмын соёлын хоцрогдлыг жинхэнэ хувьсгалт ардчилсан соёлоор солих түүхэн зайлшгүй зорилттой тулгарсан билээ.

БНМАУ-д социалист соёл бүрэлдэн тогтсон түүх нь хэд хэдэн шилжилтийн үе шат шаардсан нарийн төвөгтэй урт удаан хугацааны түүхэн процесс бөгөөд чухам үүнд манай орны соёлын хувьсгалыг онцлог оршиж байгаа юм.

Соёлын хувьсгал нь доорхи үндсэн үе шатуудад хуваагдана. Тухайлбал: хувьсгалт ардчилсан шат 1921—1940 он, социалист шат 1941—1960 он, социалист хувьсгал гүнзгийрэх шат 1960 оноос хойших үеийг тус тус хамарч байгаа бөгөөд сүүлчийн үе шат нь тус оронд социализмын материал техникийн баазыг байгуулж дуусгах үндсэн зорилтыг шийдвэрлэх үе хүртэл үргэлжилж байгаа юм.

Хөгжингүй социализм байгуулах түүхэн үед тус орон аажмаар шилжин орох цагаас монголын соёлын хувьсгалын сүүлчийн шийдвэрлэх шат болох дөрөвдүгээр шат эхлэнэ гэдгийг одоо таамаглан хэлж болмоор байна. Энэ шат бол манай соёлын хувьсгал бүх талаар цэцэглэн хөгжих түүхэн үе болох ёстой.

Соёлын хувьсгалын агуулга, зорилт, өвөрмөц шинж чанар нь харьцангуй биеэ даасан байдалтай боловч үндсэндээ ардын хувьсгалын ялалт түүний хөгжлийн түүхэн үе шатуудтай нягт уялдаа холбоотой байгаа юм.

Б. ЛХАМСҮРЭН (МАХН-ын Төв Хорооны дэргэдэх нийгмийн ухааны институтийн захирал, сурвалжлагч гишүүн)

—МАХН үүсэн байгуулагдахдаа нийгмийн бүрэлдэхүүнээрээ ч өмнөө тавьсан зорилгоороо ч ард ангийн манлайлагч нам байсан юм. Хоцрогдсон орнууд коммунист байгууллага байгуулах явдал чухал гэсэн үндэслэлээ В. И. Ленин Монголын нөхцөлд тодотгож Монгол Ардын Намыг байгуулах явдал «тэдгээрийн тэмцлийг амжилтад хүргэх нөхцөл мөн» гэж заасан билээ.

Нам зохион байгуулалтын хувьд эмхлэн байгуулагдахдаа эгнээндээ тооны хувьд цөөхөн боловч тэр үеийн монголын нийгмийн хамгийн идэвхтэй дэвшилтэт хэсгийг нэгтгэж хувьсгалт тэмцлийн зорилт, арга техникийг боловсруулсан мөрийн хөтөлбөрөөр зэвсэглэсэн байв. Колони болон феодалын байгууллагыг түлхэн унагаах тэмцэлд эрслэн орохынхоо өмнө монголын ардууд өөрийн улс төрийн манлайлагчтай болсон явдал 1921 оны Монгол ардын хувьсгал ялсны шийдвэрлэгч нөхцөлийн нэг мөн.

—Олон улсын коммунист хөдөлгөөн, түүний төв Коммунист интернационал, ЗХУКН-тай тогтоосон нягт хамтын ажиллагаа, тэдгээрийн зүйл бүрийн тусламж, хувьсгалт тэмцлийн баялаг туршлага нь МАХН, монголын ард түмний марксист-ленинист манлайлагчийн хувьд өсч БНМАУ-ыг социализмд хүрэх замаар удирдах хүч, мэдлэгийн эх сурвалж болж өгсөн юм.

Коммунист хөдөлгөөнтэй тогтоосон ах дүүгийн харилцаа холбоо, уг хөдөлгөөнөөс манай намд үзүүлсэн тусламж нь тус хөдөлгөөний тодорхой зүтгэлтэн хүмүүсээр дамжин хэрэгжиж байв.

МАХН, үүсэн байгуулагдаж, хувьсгалт тэмцлийн үзэл санаа тактикаар зэвсэглэн хөгжлийн капиталист биш замыг сонгон авсан явдал дэлхийн хөдөлмөрчдийн их багш В. И. Лениний сургаал зөвлөлгөөний шууд үр дүн байсан билээ. Манай намыг ленинч зарчим дээр байгуулж бэхжүүлэхэд Б. З. Шумяцкий нарын зэрэг лениний намын ахмад зүтгэлтэн гүн туслалцаа үзүүлж, намын жанжин шугамыг элдэв хэлбэрэл, гуйвуулалтаас хамгаалан хэрэгжүүлэхэд олон улсын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн В. Коларов, Б. Шмераль, О.Куусинен, Д. Маниульский, И. Сталин нар үлэмж хувь нэмэр оруулсныг тэмдэглэх нь чухал.

МАХН олон улсын коммунист хөдөлгөөнд идэвхтэй байр суурийг эзэлж байгаа салшгүй хэсэг нь болсон явдал бол марксизм-ленинизмийн бүтээлч сургаал, пролетарийн интернационализмын зарчимд үнэнч байсны ач мөн.

Манай нам энэ хөдөлгөөний сургамж, өөрийнхөө туршлагаас баруун ба «зүүн» оппортунизмын эсрэг, харгис үндсэрхэг үзэл маоизмын эсрэг тэмцэлд эвдэршгүй байх чанарыг өөртөө шингээж авсан юм.

Ш. НАЦАГДОРЖ (Түүхийн хүрээлэнгийн захирал, академич)

Ардын хувьсгал нь эдийн засаг, улс төр, соёлын олон үеийн хоцрогдлыг арилгах, капитализмыг алгасан социализмд аажмаар шилжин орох угтвар нөхцөлийг бэлтгэх арга хэмжээг алхам алхмаар хэрэгжүүлсэн юм. Энэ түүхэн хөгжлийн явцад хамгийн нарийн төвөгтэй асуудлын нэг нь тус орны хөдөө дэх олон зуун мянган хувийн өмчит жижиг аж ахуйтныг социалист ёсоор өөрчлөх явдал байв.

Хоршооллох явдал нь тодорхой нөхцөлөөс ялангуяа улс тус бүрийн хөгжлийн хир хэмжээнээс шалтгаалан өөрийн хэрэгжих хугацаа, хурдац, арга хэлбэр, материал техникийн баазын бэлтгэлийн байдал зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдгийг БНМАУ-ын туршлага харуулав.

БНМАУ-ын хөдөө аж ахуйг хоршооллох үйл явц хэд хэдэн өвөрмөц онцлогтой байсан юм.

1. Улс орныг нийтээр үйлдвэржүүлээгүй үед хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчилж дууссан. Энэ нь ЗХУ болон социалист бусад оронтой тогтоосон хамтын ажиллагааг хөгжүүлсний ачаар тэднээс монголын ард түмэнд бүх талын туслалцаа үзүүлж байсантай шууд холбоотой юм.

2. Чинээлэг аж ахуйтны хөрөнгийг хураалгүйгээр тэднийг нийт ардын нэгэн адил сайн дурын үндсэн дээр хоршооллосон явдал болно. Энэ нь нийгмийн байгууллын бат бэх байдал, улс орны эдийн засагт социалист хэвшил ноёрхох байдалтай болсны дээр малчин ард олны дунд МАХН асар их алдар хүндтэй байснаар тайлбарлагдах юм.

3. Бусад орон тариачдын газрыг нийгэмчлэх явдлаар л хөдөө аж ахуйн хоршоожилт эхлэдэг бол харин манай оронд 1921 оны ардын хувьсгалын ялалтын дүнд газрыг нэгэнт нийт ард түмний өмч болгон тунхагласан учир хоршооллох явцад зөвхөн малыг нийгэмчилсэн болно.

—МАХН-ын түүхэн гавъяа нь тухайлбал, хувийн өмчит малчин ардыг социализмын замд оруулах нарийн төвөгтэй зорилтыг биелүүлэх

оньсон түлхүүр В. И. Лениний хоршооллын төлөвлөгөө хэмээн үзэж өөрийн орны нөхцөлд түүнийг хэрэгжүүлэх арга замыг улс орныхоо хөгжлийн үе шат, онцлог бүрт бүтээлчээр амьдралд хэрэгжүүлэх тэмцлийг зөв удирдан чиглүүлсэнд оршино.

БНМАУ-д В. И. Лениний хоршооллын төлөвлөгөө ялсан улс төрийн ач холбогдол бол нийгмийн хөгжлийн капитализмын өмнөх шатан дээр байгаа орнууд, тэргүүний хөгжилтэй социалист орнуудын тусламжтайгаар хөгжлийн капиталист шатыг алгасан социализмд шилжин орж болох тухай марксизм-ленинизмийн сургаал өв тэгш бөгөөд хаа ч амьдрах чадалтайг дахин харуулав,

Хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчилсөн манай туршлага нь олон улсын коммунист ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, дэлхийн социалист системийн хөгжлийн онол, практикт оруулсан үнэт хувь нэмэр мөн.